

76

БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА СЭЭХИЙН ТҮГЭЭХ
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Дугаар 01



2014 оны 4 сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Хуралд оролцсон хүмүүс:

- | | |
|------------------|---|
| 1. Д.Дэлгэрцогт | ХЭХ-ийн гишүүн /Эрчим хүчний яамыг төлөөлж/ |
| 2. Р.Мөнхтуяа | ХЭХ-ийн гишүүн /Төрийн өмчийн хороог төлөөлж/ |
| 3. С.Цэнд-Аюуш | ХЭХ-ийн гишүүн /Сангийн яамыг төлөөлж/ |
| 4. Б.Сандуйжав | ТУЗ-ийн дарга |
| 5. П.Бямбацэрэн | ТУЗ-ийн гишүүн, аудитын хорооны дарга |
| 6. Ш.Доржрагчаа | БЗӨБЦТС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал |
| 7. Т.Болдсанаа | БЗӨБЦТС ТӨХК-ийн Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга |
| 8. Б.Пэрэнлиймаа | БЗӨБЦТС ТӨХК-ийн эдийн засагч, ТУЗ-ийн н/б/д нар оролцов. |

Хурал “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” хувьцаат компанийн хурлын танхимд 2014 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн 11.20 цагт эхлэв. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц 100 хувь.

Хурлыг БЗӨБЦТС ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Дэлгэрцогт удирдан хурал нээв.

Гүйцэтгэх захирал Ш.Доржрагчаа компанийн ТУЗ-ын дарга, аудитын хорооны дарга болон СЭЗХ-ийн дарга Т.Болдсанаа, ТУЗ-ын нарийн бичиг Б.Пэрэнлиймаа нарыг танилцуулсанаар хурал эхлэв.

Хурлаар хэлэлцэх асуудал:

Үүнд:

1. Компанийн 2013 оны тайлан тэнцлийн тухай
 - a. Компанийн жилийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх удирдлагын тайлангийн тухай
 - b. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах; /ТУЗ-ийн болон Аудитын хорооны тайлан/
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны зардлын гүйцэтгэл, 2014 оны зардлын төсвийг батлах
3. Ногдол ашгийн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах
4. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож батлах

Хувьцаа эзэмшигчдийн хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Дэлгэрцогт хэлэлцэх асуудлын дэс дарааллын дагуу 1-р асуудал болох компанийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн үр дүнг танилцуулахыг компанийн СЭЗХ-ийн дарга, ерөнхий ня-бо Т.Болдсанаад зөвшөөрөв.

78
Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Т.Болдсанаа : Тус компани 2013 онд "ЦДҮС" ХК-ниас 294.7 сая кВт*ц цахилгаан эрчим хүчийг худалдан авч нийт 26674.0 сая төгрөгийн орлоготой, 27848.7 сая төгрөгийн нийт зардалтай, 1175.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. 2013 онд 3393.8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 35670,6 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө, нийт 39064.5 сая төгрөгийн хөрөнгөтэйгөөр тайлан тэнцэлд тусгагдлаа. Тайлант хугацааны эцэст авлага 1404.1 сая төгрөг, богино хугацаат өр төлбөр тайлант хугацааны эцэст 3844,9 сая төгрөг болсон байна.

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: Гишүүдээс хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдуулан асууж тодруулах зүйл байвал асууцгаана уу. Миний хувьд санхүүгийн тайлангийн талаарх үзүүлэлтүүдийг батлах саналтай байна.

Хөрөнгө оруулалт ТЗБАХ-ын зардлууд нилээд хэтэрсэн байна. 2013 онд өмнөө тавьсан зорилгоо биелүүлж алдагдалаа бууруулж ажилласан байна.

Т.Болдсанаа СЭЗХ-ийн дарга: Ажил бол төлөвлөгдсөн хэмжээгээр 100 хувь хийгдсэн байгаа. Бараа материал хөрөнгө оруулалт, их засвартай холбоотой сэлбэг, материалын худалдан авалт үнийн өсөлттэй холбоотой бага зэрэг хэтэрсэн байгаа.

Гүйцэтгэх захирал Ш.Доржрагчаа: 2013 оны 8 сард манайх төрийн өмчийн хороогоор толотгосон төлөвлөгөө оруулсан. Тэр төлөвлөгөөгөөр хөрөнгө оруулалтын хэмжээг бууруулж, 200-аад сая төгрөгийн ажлыг хассан байгаа. Зардал дээр цалинг 20 хувь нэмсэн.

ХЭХ-ийн гишүүн С.Цэнд-Аюуш: Зардлын төсөв дээр цалингаа нэмж оруулсан байна тийм үү. Батлах саналтай байна.

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: Зардлуудаа бүрэн зарцуулсан байна. Орлого алдагдлаас бусад үзүүлэлтүүд нь биелэгдсэн байна. Цэнд-Аюуш гишүүнтэй санал нэг байна. Тогтоолын төсөл 2013 оны 12 сарын 31-ний өдрөөр гэж нийт хөрөнгийн дүнг бичнэ. За ийм засвар хийгээд тогтоолын төслийг батлах саналтай байна.

Мөн энэ тогтоолын төсөл дээр өр авлага бууруулах гэж 2-р заалтан дээр өгүүлбэр нэмж оруулах саналтай байна.

ХЭХ-ийн гишүүн Д.Дэлгэрцогт За та бүхэнд өөр санал байна уу. Байхгүй бол тайлант ингээд 2 асуудлыг баталъя. Дараагийн асуудал руу оръё.

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: Ингээд 1-р асуудлыг баталлаа.

ХЭХ-ийн гишүүн С.Цэнд-Аюуш: Цаашдаа хангалттай сайн ажиллаарай. 2-р асуудал руу оръё.

ТУЗ-ын дарга Б.Сандуйжав: ТУЗ-ын 2013 оны тайлан танилцуулъя. Төлөөлөн удирдах зөвлөл нь Б.Сандуйжав, Д.Тунгалагтуул, С.Цэрэнжамц, Д.Болортуяа, Б.Төгөлдөр, П.Жаргалсайхан, хараат бус гишүүдээр П.Бямбацэрэн, Г.Бэхбат, Н.Намхай гэсэн 9 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна. 2013 онд нийтдээ 6 удаа хуралдаж, 34 асуудлыг хэлэлцсэн байна. 27 тогтоол, шийдвэрүүдийг гаргаж, компанийн удирдлагад үүрэг даалгавар зөвлөмжүүдийг өгч ажилласан байна. Компанийн 2013 оны зорилтог түвшингийн төлөвлөгөө, түүний биелэлт хүлээгдэж буй гүйцэтгэл, 2013 оны бүтэц орон тоо, 2012 оны худалдан авах ажиллагааны үр дүн, 2012 оны аудитын тайлан, 2013 оны хийх ажлын тайлан, ТУЗ-ын зардлын гүйцэтгэл, зардлын төсөв, гүйцэтгэх захирлын гэрээ сунгах, ажиллагсадын жилийн үр дүнгийн шагнал, 2013 оны эхний хагас жилийн тайлан тэнцэл, 2013 оны үнэ тарифын асуудал, тододгосон төлөвлөгөө, их засвар ТЗБАХ хөрөнгө оруулалтын ажлын биелэлт, жилийн эцсийн тайлан тэнцэл болон бусад асуудлуудыг шийдвэрлэж баталсан байна. Мөн Монголросцветмет ХХК-с авах авлагыг шүүхээр шийдүүлэх талаар олон удаа мэдэгдэл хүргүүлж байсан. Авлага барагдуулах талаас гэрээ хийж 2 талаас яамтай хамтран тохиролцсон боловч өнөөг хүртэл авлагын асуудал яригдсан хэвээрээ байна. Бор өндөрийн уурхай ажиллахгүй байгаатай холбоотой энэ авлагын асуудал байгаад байгаа. Нөгөө талд яг энэ дүнгээрээ нэг худалдан авагчдаа өглөг үүсээд байгаа. Аудитын тайлангийн талаар П.Бямбацэрэн гуай танилцуулах уу.

ТУЗ-ын хараат бус гишүүн аудитын хорооны дарга П.Бямбацэрэн: Аудитын хорооны тайлангийн талаар товч танилцуулъя. 2013 оны 4 сар хүртэл хуучин 2 гишүүн Дэлгэрмаа, Н.Намхай, төрийн өмчийн хорооны төлөөлөл гээд 3 гишүүн ажилласан. 2013 оны 4 сараас

хойш П.Бямбацэрэн, Г.Бэхбат, төрийн өмчийн хорооноос Д.Болортуяа гэсэн хараат бус гишүүд ажилласан.

Нэгдүгээрт: Компанийн хуулийн дагуу аудитын хороо нь гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтэнд хяналт тавих, компанийн эдийн засгийн үзүүлэлтэнд хяналт тавих, төлөвлөгөөний биелэлт, төлөвлөгөөнд тодотгол хийх, үр дүнгийн шагнал гаргах зэрэгт үнэлэлт дүгнэлт гаргаж, зохих хяналтыг тавьж ажилласан. ТУЗ-ын 6 удаагийн 3-т нь аудитын хороо дүгнэлтээ гаргасан. 2013 оны гол анхаарлаа төвлөрүүлсэн асуудлууд болбол ерөнхийдөө ажиллагсадын цалингийн дундаж салбарын хэмжээнд хамгийн доогуур байсан. Иймд энэ байдалд үндэслэн тооцоо гаргаж, тариф нэмэхэд санал дүгнэлтээ оруулж, шийдвэрлэх чиглэлд анхаарч ажилласан.

Хоёрдугаарт: Үндсэн хөрөнгийн элэгдлийг засгийн газрын тогтоолын дагуу бүрэн хэмжээгээр байгуулдаг болоход гүйцэтгэх захирлын ажлын багт чиглэл өгч, төлөвлөгөөний тодотгол болон энэ төлөвлөгөөний үндэслэл тооцоо зэрэгт санал зөвлөмж өгч ажилласан байна. Өр авлага барагдуулах асуудлыг хэлэлцэх, төрийн өмчийн хорооны даргаас өр барагдуулах тал дэмжлэг үзүүлэх тал дээр туслалцаа хүсэх, төлөвлөгөө батлуулах зүйлүүд дээр мөн анхаарал тавьж ажилласан. Бүхэлд нь авч үзвэл компани нь 2013 оныхоо төлөвлөгөө зорилтыг бүрэн биелүүлсэн гэж үзээд хангалттай ажиллаж байна гэсэн дүгнэлтийг өгч байгаа юм. 2014 оны төлөвлөгөөн дээр цаашид хэрхэн ажиллах талаар мөн тусгасан байгаа.

ХЭХ-ийн гишүүн Д.Дэлгэрцогт: За асуух зүйл байна уу?

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: Үндсэн хөрөнгийн элэгдэл бүрэн байгуулагддаггүй гэдэг чинь юу билээ?

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Т.Болдсанаа: Манайх аж ахуй нэгжийн татварын хуулийн дагуу хувь хэмжээгээр нь явж ирсэн. Одоо засгийн газрын 233 тогтоолоор шилжихээр, НББ-ийн бодлогын бичиг баримтанд тусгасан. Энэ оны бизнес төлөвлөгөөнд оруулж батлуулсан байгаа учир энэ оноос шилжих гэж байгаа.

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: Тарифт тэгээд яаж суух вэ?

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Т.Болдсанаа:

Тарифт ч гэсэн жуучин байгуулж байсан татварын хуулиараа явж байсан.

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: Цахилгаан дамжуулах шугам татварын хуулиар 8 хувь билүү.

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Т.Болдсанаа: Цахилгаан дамжуулах шугам татварын хуулиар 40 жил гэж байгаа харин ЗГ-ын 233-р тогтоолоор 10 жил гэсэн байгаа.

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: Гэхдээ та нар заавал ЗГ-ын тогтоол 233-ыг заавал барих албагүй шүү дээ. Энэ талаараа бодлогын баримт бичигтээ тусгаад явах ёстой.

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Т.Болдсанаа:

Тухайн үед ТУЗ-аараа хуралдаад, ЗГ-ын 233 тогтоолын дагуу элэгдэлээ тооцож явахаар шийдвэр гарсан.

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: Тэгээд энэ асуудал тарифт сууж чадах уу.

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Т.Болдсанаа: Энэ оны 4 сараас мөрдөж эхлэхээр төлөвлөгөөнд суугдаад байгаа.

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: 233-р тогтоолынхоо дагуу тарифдаа сууж чадаж байгаа бол болж л байна. Одоо ингээд мөрдөөд явахад аудитаас элэгдэл дутуу байгуулагдсан гэсэн асуудал яригдана. Тэгэхээр эхлээд бодлогын баримт бичигтээ тусгах ёстой.

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Т.Болдсанаа: Бодлогын баримт бичигтээ тусгасан байгаа.

ТУЗ-ын хараат бус гишүүн аудитын хорооны дарга П.Бямбацэрэн

Зарчмын чиглэлээ ТУЗ-д оруулаад батлуусан байгаа. 2014 оны эцэстээ бүрэн орчих болов уу гэсэн баримжаатай байна.

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Т.Болдсанаа: Зохицуулах хорооноос санхүүгийн тайландаа элэгдлээ байгуулж ирсэн хойно тарифт оруулах асуудлыг ярина гээд байгаа. Тэгж байгаа учраас бид энэ оноос оруулаад явна гэсэн бодолтой байна.

ТУЗ-ын дарга Б.Сандуйжав: Шугамнууд 233-р тогтоолоор бол ашиглах жил дуусчихсан байгаа, харин татварын хуулиараа ашиглах жил дуусаагүй учир шугамнууд нь тасралт ихтэй, аваар ослын байдал үүсгэх магадлалтай, ашиглалтын байдал муудсан, сунасан сүлжээ учраас 233-р тогтоолоороо явбал зүгээр юм байна гэж үзсэн байгаа.

ХЭХ-ийн гишүүн Д.Дэлгэрцогт: За ТУЗ-ын тайлан, аудитын хорооны тайланг батлах уу? 2015.01.13

Бүгдээрээ.
ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: Тогтоолын төсөл дээрээ хангалттай гэсэн үнэлгээгээ 2 тусдаа тусдаа биш нийлүүлж үнэлээд хангалттай гэж бичих хэрэгтэй. Тэгэхгүй бол 2 тусдаа байгууллага юм шиг харагдаад байна. Миний хувьд батлах саналтай байна.

ХЭХ-ийн гишүүн С.Цэнд-Аюуш: Батлах саналтай байна.

ХЭХ-ийн гишүүн Д.Дэлгэрцогт: Дараагийн асуудал болох ТУЗ-ын 2014 оны зардал батлах тухай гэсэн асуудлаа хэлэлцье.

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: 2013 оны зардлаас нэлээд их өссөн байна. Хуучин цалин хэд байсан бэ.

ТУЗ-ын нарийн бичгийн дарга Б.Пэрэнлиймаа: Хуучин дарга 150,000, гишүүд 130,000, нарийн бичиг 100,000 төгрөг байсан.

ХЭХ-ийн гишүүн С.Цэнд-Аюуш: Энэ томилолтын зардлыг шатахуунаас нь салгахгүйгээр нэгтгэж бич. Томилолтын зардал дотроо орно. Миний хувьд энэ оруулж ирсэн хэмжээгээр нь батлах саналтай байна.

ХЭХ-ийн гишүүн Д.Дэлгэрцогт: Батлая. За дараагийн асуудал ногдол ашгийн талаар хэлэлцье. Алдагдалтай ажилласан учир ногдол ашиг байхгүй юм байна. Энэ хэвээр батлах уу.

ХЭХ-ийн гишүүн С.Цэнд-Аюуш: Батлая.

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: Батлах саналтай.

ХЭХ-ийн гишүүн Д.Дэлгэрцогт: Дараагийн асуудал хөрөнгө нэмэгдүүлэх тухай юм байна. Та бүхэнд санал байна уу. Байхгүй бол батлах уу.

ХЭХ-ийн гишүүн С.Цэнд-Аюуш: Батлах саналтай байна.

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: Батлах саналтай гэснээр хурлын үйл ажиллагаа өндөрлөв.

ХЭХ-ийн гишүүн С.Цэнд-Аюуш: Хараат бус гишүүнийг байгаагаар нь батлах саналтай байна.

ХЭХ-ийн гишүүн Р.Мөнхтуяа: Миний хувьд мөн ижилхэн саналтай байна.


ХЭХ-ийн гишүүн Д.Дэлгэрцогт: Батлая.

Хурлаас шийдвэрлэсэн нь:


1. Компанийн 2013 оны санхүүгийн тайлан тэнцлийн үр дүнг хэлэлцээд Хувьцаа эзэмшигчдийн хурлаас :
 - Нийт хөрөнгийг 39 064 491,4 мянган төгрөгөөр
 - Эргэлтийн бус хөрөнгийг 35 670 686,6 /элэгдэл хассан дүн/ мянган төгрөгөөр
 - Эргэлтийн хөрөнгийг 3 393 804,8 мянган төгрөгөөр
 - Эзэмшигчийн өмчийн хөрөнгийг 35 219 542,3 мянган төгрөгөөр ,
 - Нийт авлагыг 1 404 127,6 мянган төгрөгөөр
 - Нийт өглөгийг 3 844 949,1 мянган төгрөгөөр
 - Цэвэр алдагдлыг 1 175 640,8 мянган төгрөгөөр тайлан тэнцлийн дүнг тус тус баталсан тогтоол гаргахаар
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны ажлын тайланг "Хангалттай" гэж дүгнэн компанийн зорилтыг ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хуулийн дагуу хяналт тавьж ажиллах,

- ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж, гишүүдийн хариуцлага, идэвхи санаачилгыг дээшлүүлж ажиллахыг ТУЗ-ийн даргад үүрэг болгосон заалттай тогтоол гаргахаар
3. Компанийн 2014 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг 42242,1 мянган төгрөгөөр баталж, гишүүдийн цалин хөлсийг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосон заалттай тогтоол гаргахаар
4. Компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013 онд хийгдсэн, Төрийн өмчийн хорооны тогтоолоор бүртгэлд тусгагдсан цахилгаан дамжуулах агаарын шугам, тоноглолын нийт 4 653 259 039 /Дөрвөн тэрбум зургаан зуун тавин гурван сая хоёр зуун тавин есөн мянга гучин есөн/ төгрөгийн хавсралтад заасан хөрөнгийн дүнгээр нэмэгдүүлэхийг компанийн гүйцэтгэх захиралд зөвшөөрч, компанийн дүрмийн 3.1 дэх заалтын “100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 224,203,849 ширхэг хувьцаатай” гэснийг “100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 270,736,439 ширхэг хувьцаатай” гэж өөрчилж, холбогдох газарт бүртгүүлэхийг гүйцэтгэх захиралд даалгасан, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосон тогтоол гаргахаар
5. 2013 оны тайлан тэнцлийн дүнгээр 1,175,640.8 / Нэг тэрбум нэг зуун далан таван сая зургаан зуун дөчин мянга найман зуун/ төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тогтоол гаргахаар
6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр Б.Сандуйжав, Д.Болортуяа, Д.Тунгалагтуул, П.Жаргалсайхан, С.Цэрэнжамц, Б.Төгөлдөр нарыг, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр П.Бямбацэрэн, Н.Намхай, Г.Бэхбат нарыг сонгож, баталсан тогтоол гаргахаар тус тус хэлэлцэн шийдвэрлэж, хурал амжилттай явагдаж 12 цаг 30 минутад өндөрлөв.

Хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлтэй танилцсан:
ХЭХ-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч,
Хурлын дарга

 Д.Дэлгэрцогт

Хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлсөн:
ТУЗ-ийн н/б/д

 Б.Пэрэнлиймаа